

## ХУРАЛДААНЫ ТОЙМ

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНЫ ХОРИНЕСДҮГЭЭР ХУРАЛДААН

Хуралдаан 2016 оны есдүгээр сарын 22-ны 14 цаг 10 минутад эхэлж, 15 цаг 19 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 09 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Үндэсний хөгжил, хөрөнгө оруулалт хариуцсан дэд даргын, орон нутгийн асуудал хариуцсан дэд даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “б”-д заасныг тус тус баримталж, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах комиссын 25, 26 дугаар дүгнэлтүүдийг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанаас:</p> <p>Базархүүгийн Даажамбыг Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Үндэсний хөгжил, хөрөнгө оруулалт хариуцсан дэд даргын, Ургамалын Бямбасүрэнг Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Орон нутгийн асуудал хариуцсан дэд даргын албан тушаалд тус тус томилуулахаар нэр дэвшүүлж, Монгол Улсын Засгийн газарт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
2	Засгийн газрын тохируулагч агентлаг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын Тамгын газрын даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг</p>

		<p>сонгон шалгаруулах журам"-ын 14-ийн "б"-д заасныг тус тус баримталж, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах комиссын 24 дүгээр дүгнэлтүүдийг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанаас:</p> <p>Даваадоржийн Өнөболдыг Засгийн газрын тохируулагч агентлаг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын Тамгын газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
--	--	---

## **ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА**